



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, 2024 оны Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/166, А/63, А/73 дугаар тушаалаар батлагдсан "Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 12.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2025 оны Үндэсний урлагийн их театрын албан хаагчдын үр дүн, ур чадварын нэмэгдлийг тооцож олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч
Гишүүд:

Уран сайхны удирдагч
Захиргаа, үйлдвэрлэл үйлчилгээний
хэлтсийн дарга
Туслах найруулагч
Хөгжим албаны дарга
Бүжиг албаны дарга
Дуу албаны дарга
Тайз, гэрэл, дуу техникийн алба
Хүний нөөцийн менежер

2.Шалгуур үзүүлэлтийн дагуу албан хаагчдын ур чадварын үнэлгээг дүгнэн улирлын сүүлийн 20-ны өдрийн дотор баталгаажуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

3.Шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсгийн үнэлсэн үнэлгээг үндэслэн, батлагдсан төсөвт багтаан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Батсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ

Г.ЦОГГЭРЭЛ

